



ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ЦАГААННУУР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 01 сарын 02 өдөр

Дугаар 5/02.

Гурвансайхан

Бадам овогтой Булагбаярыг ажлаас
чөлөөлөх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 78 дугаар зүйлийн 78.1, Төрийн албаны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2.5 дахь заалт, 43 дугаар зүйлийн 43.1, 94 дүгээр зүйлийн 94.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Цагааннуур сумын 1-р багийн Засаг дарга Б.Булагбаярыг сонгуулийн үр дүнгээр 2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөр тасалбар болгон үүрэгт ажлаас нь чөлөөлсүгэй.

2. 1-р багийн Засаг даргын ажил хүлээлцэх комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Комиссын дарга: З.Золбоо-(ЗДТГ-ын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Нарийн бичгийн дарга: Б.Оюундарь-(Хууль, эрх зүйн мэргэжилтэн)

Гишүүд:

Д.Баярмагнай-(нярав)

Л.Шижирболд-(нягтлан бодогч)

Б.Баасансүрэн-(Хүнс, ЖДҮ, хоршооны асуудал хариуцсан мэргэжилтэн)


3. Багийн Засаг даргад холбогдох баримт бичиг болон эд материалыг хүлээн авч холбогдох баримт бичгийг бүрдүүлэн ажиллахыг ажлын хэсгийн дарга (З.Золбоо)-д үүрэг болгосугай.

4. Б.Булагбаярт урьд нь авч байсан албан тушаалын 6 сарын цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн тэтгэмж болон ажилласан хугацааны ээлжийн амралтын мөнгийг бодож олгохыг ЗДТГ-ын нягтлан бодогч (Л.Шижирболд)-д зөвшөөрсүгэй.

5. Захирамжийг мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдол гаргах эрхтэйг дурдсугай.

6. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Б.Гэрэлт-Од)-д даалгасугай.

ДАРГА



Д.ОТГОНСҮРЭН

672601002